



248

## УЛСЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2009 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 186

Улаанбаатар хот

### Журам шинэчлэн батлах тухай


Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дугаар заалт, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм”-ийн 16 дугаар зүйлийн “к” заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Ажил, хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоох журам”-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

Хоёр. Энэ журам батлагдсантай холбогдуулан тэтгэврийн тооцооллын програм хангамжид холбогдох өөрчлөлт оруулж, төв, орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэх арга хэмжээ авахыг Мэдээлэл, тооцоолол, сургалтын төв /Г.Хүрэлбаатар/, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханганд ажиллахыг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар/Ц.Дашдондог/, журмын хэрэгжилтэд хяналт тавихыг Хяналт, үнэлгээний газар /Ё.Пүрэвцэрэн/-т тус тус үүрэг болгосугай.


Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дэд дарга /Ж.Эрдэнэбаатар/-д даалгасугай.

Дөрөв. Энэ тушаал гарсантай холбогдуулан Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2006 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 90 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Ч.АЛТАНХУЯГ

Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын  
даргын 2009 оны 04 дүгээр сарын 08-ны  
өдрийн 136 тоот тушаалын хавсралт



## АЖИЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛСӨН ТЭТГЭВЭР АВАГЧИЙН ТЭТГЭВРИЙГ ӨӨРЧЛӨН ТОГТООХ ЖУРАМ

1. Энэхүү журмыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дугаар заалт, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтооход баримтална.

2. Хуулийн эдгээр заалтын дагуу тэтгэвэр өөрчлөн тогтооход Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 5, 6 дахь хэсгүүдэд заасны дагуу өндөр насны, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу тахир дутуугийн, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн дагуу цэргийн алба хаасны, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу цэргийн тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгосны дараа Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар ажил, хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн (цэргийн алба хаасан), уг шимтгэл төлсөн хугацааг нь анх тэтгэвэр тогтооход баримталсан шимтгэл төлсөн хугацаа (цэргийн алба хаасан)-тай нэгтгэн тооцоход нийт шимтгэл төлсөн хугацаа нь өндөр насны болон тахир дутуугийн тэтгэвэр авагч бол 20 жил, цэргийн албан хаагч бол 25 жил (цэргийн албан хаагч эмэгтэй бол 20 ба дээш, байлдааны нисдэг тэрэгний нисгэгч бол 23 ба дээш, байлдааны тийрэлтээ сөнөөгч онгоцны нисгэгч бол 20 ба дээш) ба түүнээс дээш жилд хүрэх тэтгэвэр авагчид хамарагдана.

3. Энэ журмын 2 дахь хэсэгт заасан иргэдийн тэтгэврийг тэдний тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлт гаргасан үед авч байсан тэтгэврийн хэмжээг тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлж ажилласан 12 сар буюу 1 жил тутамд анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан дундаж цалин хөлснөөс энгийн тэтгэвэр авагч бол Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хувь хэмжээгээр буюу 1.5 хувиар, цэргийн тэтгэвэр авагч бол Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр буюу 1.0 хувиар тооцсон дүнгээр нэмэгдүүлэх замаар өөрчлөн тогтооно.

4. Нийгмийн даатгалын сангаас болон цэргийн албан хаагчийн тэтгэврийг бүрэн тэтгэврийн доод хэмжээгээр тогтоолгон авч байгаа, энэ журмын 2 дахь хэсэгт заасан болзлыг хангасан тэтгэвэр авагчийн тэтгэврийг тэтгэврээ өөрчлөн тогтоолгох үед авч байсан бүрэн тэтгэврийн доод хэмжээн дээр мөн журмын 3 дахь хэсэгт заасан хэмжээгээр тооцсон дүнгээр нэмж өөрчлөн тогтооно.

5. Нийгмийн даатгалын сангаас болон цэргийн албан хаагчийн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгосон тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолгосноос хойш ажил, хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тэтгэвэр анх тогтооход баримталсан шимтгэл төлсөн хугацаатай нэгтгэн тооцоход холбогдох хуулиудад заасан бүрэн тэтгэврийн эрх үүсэх болзлыг хангахаар бол эдгээр иргэдийн тэтгэврийг бүрэн тэтгэвэр болгон өөрчлөн тогтооно.

6. Тэтгэвэр авагчийн энэ журмын 5 дахь хэсэгт заасан шимтгэл төлсөн хугацаа нь бүрэн тэтгэвэр тогтоох хугацаанд хүрэхгүй иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэхгүй хэвээр нь олгоно. Харин эдгээр иргэдийн шимтгэл төлсөн хугацааг нь шинэчлэн тооцож, мэдээллийн баазад оруулан, тэтгэврийн дэвтэрт нь бичилт хийж, баталгаажуулж өгнө.

7. Энэхүү журмын дагуу иргэдийн тэтгэврийг өөрчлөн тогтоохдоо дараахь баримт бичгийг үндэслэнэ. Үүнд:

7.1. Тэтгэвэр өөрчлөн тогтоолгохыг хүссэн өргөдөл;

7.2. 1995 оноос өмнөх хугацаагаар тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлт гаргасан бол хөдөлмөрийн дэвтэр,

7.3. 1991-1995 он хүртэл хугацаанд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байсан бол тухайн тэтгэвэр авагчийн ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллагын шимтгэл төлсөн тухай холбогдох нийгмийн даатгалын хэлтсийн архивын лавлагаа;

7.4. 1995 оноос хойшхи хугацаагаар тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлт гаргасан бол баталгаажсан нийгмийн даатгалын дэвтэр.

8. Энэ журмын дагуу өргөдөл гаргасан иргэдийн өөрчлөгдсөн тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацааг баримтлан олгоно.